



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/61/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Энхдалай  
Утас: 261885 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул  
Утас: 261740 Цахим хаяг: [erdenezulb@audit.gov.mn](mailto:erdenezulb@audit.gov.mn)  
Гэрээгээр гүйцэтгэсэн Гроут финанс Аудит ХХК-ийн  
Захирал Б.Бямба  
Утас: 99094391 Цахим хаяг: [byambaa@growthfinance.mn](mailto:byambaa@growthfinance.mn)  
Аудитор: М.Насанбат  
Утас: 99190864 Цахим хаяг: [nasanbat@growthfinance.mn](mailto:nasanbat@growthfinance.mn)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

|  |    |
|--|----|
| 1. Аудитын санал дүгнэлт .....   | 3  |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....  | 7  |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....                                 | 7  |
| 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....                                | 8  |
| 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....                                 | 9  |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....                                  | 10 |
| 2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл ..... | 11 |
| 3. Аудитын тайлан .....  | 12 |
| 3.1 Ерөнхий зүйл .....   | 12 |
| 3.2 Дотоод хяналт .....  | 12 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....                                  | 13 |
| 3.4 Материаллаг байдал .....   | 13 |
| 4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....   | 14 |
| 4.1 Байгууллагын үйл ажиллагаа .....   | 14 |
| 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....                   | 14 |
| 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....                                       | 15 |
| 4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....            | 18 |
| 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....        | 19 |
| 5.1 Шилэн дансны мэдээлэл .....  | 19 |
| 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....  | 19 |
| 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....                      | 20 |
| 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....                                     | 21 |
| 8. Аудитын илрүүлэлт .....   | 22 |
| 8.1 Залруулсан алдаа .....   | 22 |
| 8.2 Албан шаардлага .....  | 22 |
| 8.3 Зөвлөмж .....  | 23 |
| 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....                                | 26 |
| 10. Хавсралт: Албан шаардлага .....  | 30 |

**Товчилсон үгийн жагсаалт**

|          |   |
|----------|---|
| ААНОАТ   | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар                 |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт         |
| АМНАТ    | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр                 |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                           |
| НБББББ   | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг        |
| НББОУС   | Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт          |
| СТОУС    | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт            |
| ТӨБЗГ    | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар             |
| ТУЗ      | Төлөөлөн удирдах зөвлөл                               |
| ТЭЗҮ     | Техник эдийн засгийн үндэслэл                         |
| ЭТТ ХК   | Эрдэнэс Тавантолгой ХК                                |
| ЭТТМ ХХК | Эрдэнэс Тавантолгой Майнинг ХХК                       |
| БЗЭБЭБХ  | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө |



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ГАНХУЯГ  
ТАНАА

2022.03.15 № 07/632  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хараат бус аудиторын тайлан

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон зүйл

2021 онд Ковид цар тахлын улмаас экспорт өмнөх оноос эрс буурсан нь компанид санхүүгийн хүндрэлтэй байдал, мөнгөн хөрөнгийн дутагдал бий болж үүнээс үүдэн компанийн хэрэгжүүлж буй томоохон бүтээн байгуулалтын төслүүдийн санхүүжилтийг гадаад болон дотоод зах зээлд үнэт цаас гаргах “ЭТТ Бонд”, арилжааны банкны зээлийн эх үүсвэрээр шийдвэрлэн ажилласан байна.

Монгол Улсын Засгийн газрын “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын төлөвлөгөө”-ний хүрээнд “ЭТТ БОНД”-ын 1, 2 дугаар транчийн арилжааг амжилттай зохион байгуулж 692.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлж, төслүүдийн санхүүжилтийг үргэлжлүүлэн, Тавантолгой дулааны цахилгаан станц, Нүүрс баяжуулах үйлдвэр, Усан хангамж, Төмөр замын төслүүдийг санхүүжүүлэхэд зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 185 дугаар тогтоолоор Чингэлэг тээврийн терминалыг байгуулах ажлыг “Энержи Ресурс” ХХК гүйцэтгэсэн бөгөөд “Эрдэнэс Тавантолгой” ХК зардлын 60 хувийг санхүүжүүлж, менежментийн гэрээ байгуулан ажиллаж байна. Өмнөговь аймгийн Гашуунсухайт хилийн боомт дахь чингэлэг тээврийн

терминал нь нийт 30 га талбайг хамарсан бөгөөд 8,100 чингэлэг буюу 259,200 тонн нүүрсний багтаамжтай. Чингэлэг ачиж, буулгах /Калмар/ 5 техникээр жилд 8 сая тонн хүртэл нүүрс ачиж буулган экспортлох хүчин чадалтай томоохон бүтээн байгуулалт юм. Терминалын ачиж буулгах тоног төхөөрөмж, техникийн хүчин чадлыг талбайн чингэлэг тээврийн эрчимтэй уялдуулан үе шаттай нэмэгдүүлснээр терминалаас экспортлох нүүрсний хэмжээ 19 сая тоннд хүрэх боломжтой юм.

Уул уурхайн нөхөн сэргээлтийн нөөц санг тооцоолоход үндэслэх суурь үнэлгээ, нэгж, үнэ тариф, тухайн жилийн зах зээлийн үнэ ханш, нөхөн сэргээлт хийхтэй холбоотой зардлын мөнгөн дүнг хэмжиж тооцоолох зохистой арга зүйг хэрэглэх, НББОУС 37-ын 59-д заасан “Нөөцийг тухайн тайлант үе бүрийн эцэст нягталж шалгах бөгөөд одоогийн хамгийн сайн тооцооллыг тусгахын тулд түүнийг тохируулна” гэсэн заалтын дагуу дахин хянаж үзэх шаардлагатай.

### **Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 29 өдрийн 45 дугаар тогтоолоор нийт орлогыг 2,005,451.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,696,003.5 сая төгрөгөөр, 309,448.1 сая төгрөгийн ашигтай ажиллахаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 3,345,722.6 сая төгрөг зарцуулахаар өөрчлөн баталж өгсөн байна.

Тайлант онд гүйцэтгэлээр 1,165,165.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,000,849.6 сая төгрөгийн зардал гарган, 164,315.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 3,345,722.6 сая төгрөг зарцуулахаас 800,367.5 сая төгрөг зарцуулж 23.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу 2021 оны үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээний 115 худалдан авах ажиллагаанд 4,896,547.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

### **Бусад асуудал**

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, 1072 хувьцааны мэдээлэл, олон улсын хөтөлбөр, дадлагажуулах хөтөлбөр, ажлын байрны бүртгэл, сургалт, С зөвшөөрөл зэрэг цахим үйлчилгээг өөртөө нэгтгэсэн “ETT” апплейшнийг хэрэглээнд нэвтрүүлэн 1.1 сая хандалт авч, 449,000 хэрэглэгч татсанаар иргэд, аж ахуйн нэгж, хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулсан байна.

Компанийн засаглалын нээлттэй, ил тод байдлыг хангах, төр, аж ахуй нэгж, хувьцаа эзэмшигч иргэдийг мэдээллээр хангахтай холбогдуулан “Шилэн компани” хөтөлбөрийг хэрэгжүүлж компанийн үйл ажиллагаатай холбоотой 9500 орчим хуудас материалыг [www.ett.mn](http://www.ett.mn) цахим хуудсанд байршуулж, “Нүүрс тээврийн цахим цонх”-ыг ажиллуулсан байна.

Гүйцэтгэх захирлын тушаалаар 2021 онд дуудлага худалдаа зохион байгуулах журмыг боловсруулан баталж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А-1/694 тоот удирдамжийн дагуу дуудлага худалдааг зохион байгуулсан байна.

Засгийн газрын 2021 оны 169 дүгээр тогтоолоор Коронавируст халдвар Ковид-19 цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд шаардлагатай вакцин тариур, урвалж, дагалдах хэрэгсэл түргэвчилсэн оношлуур, вирусын эсрэг эм худалдан авах болон шуурхай мэдээлэл 119 төвийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай зардлыг Эрдэнэс Тавантолгой ХК-аас санхүүжүүлэхээр тогтоосны дагуу уг арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн яамтай 29.0 тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлэх гэрээ байгуулан, компанийн 2021 оны тодотгосон төлөвлөгөөнд нийгмийн хариуцлагын зардлаар тусгаж, үүнээс 15.8 тэрбум төгрөгийн урьдчилгаа олгосон байна. Засгийн газрын 2021 оны 112 тоот тогтоолоор 1.0 сая тун вакцины зардлыг Эрдэнэс Тавантолгой ХК-аас санхүүжүүлэх шийдвэр гаргасны дагуу ОХУ-н Хюмэн вакцин ХХК /Human vaccin LLC/-д шилжүүлсэн байна.

Засгийн газрын 2020 оны 12 сарын 02-ны өдрийн 200 дугаар тогтоолоор Тавантолгой түлш ХХК-ийн Нийслэлийн иргэдэд олгосон нүүрсний үнийн хөнгөлөлтийн зөрүүг тонн тутамд 50 хувиар буюу 61,245.9 сая төгрөгийг Эрдэнэс Тавантолгой ХК санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

### **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 50 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт  | /төгрөгөөр/                  |                              |
|---------------|---|------------------------------|------------------------------|
|               |   | 2020 оны<br>12-р сарын 31    | 2021 оны<br>12-р сарын 31    |
| <b>1</b>      | <b>ХӨРӨНГӨ</b>  |                              |                              |
| <b>1.1</b>    | <b>Эргэлтийн хөрөнгө</b>  |                              |                              |
| 1.1.1         | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө   | 134,579,817,564.83           | 49,182,155,244.52            |
| 1.1.2         | Дансны авлага   | 22,750,533,629.22            | 2,641,275,089.45             |
| 1.1.3         | Татвар, НДШ - ийн авлага  | 2,925,855,367.51             | 5,389,767,019.59             |
| 1.1.4         | Бусад авлага  | 8,533,994,273.71             | 14,385,034,720.05            |
| 1.1.5         | Бараа материал  | 129,688,069,920.17           | 263,756,064,831.34           |
| 1.1.6         | Урьдчилж төлсөн зардал/тооцоо   | 898,673,489,044.94           | 1,613,359,984,228.79         |
| 1.1.7         | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | 392,534,246.50               | (0.00)                       |
| <b>1.1.8</b>  | <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>  | <b>1,197,544,294,046.89</b>  | <b>1,948,714,281,133.74</b>  |
| <b>1.2</b>    | <b>Эргэлтийн бус хөрөнгө</b>  |                              |                              |
| 1.2.1         | Үндсэн хөрөнгө  | 46,918,974,558.66            | 110,961,149,188.46           |
| 1.2.2         | Биет бус хөрөнгө  | 11,138,815,800,462.80        | 11,126,449,728,468.80        |
| 1.2.3         | Урт хугацаат хөрөнгө оруулалт   | 309,341,309,157.49           | 308,599,116,000.00           |
| 1.2.4         | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө   | 15,832,974,521.81            | 16,453,934,936.83            |
| 1.2.5         | Хойшлогдсон татварын хөрөнгө  | 41,780,018,808.29            | 116,334,261,226.67           |
| 1.2.6         | Бусад эргэлтийн бус хөрөнгө   | 1,384,886,624,342.70         | 1,690,218,439,615.90         |
|               | <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>  | <b>12,937,575,701,851.80</b> | <b>13,369,016,629,436.70</b> |
| <b>1.3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>   | <b>14,135,119,995,898.70</b> | <b>15,317,730,910,570.40</b> |
| <b>2</b>      | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>  |                              |                              |
| <b>2.1</b>    | <b>Өр төлбөр</b>  |                              |                              |
| 2.1.1         | <b>Богино хугацаат өр төлбөр</b>  |                              |                              |
| 2.1.1.1       | Дансны өглөг  | 370,019,327,697.83           | 142,595,124,456.93           |
| 2.1.1.2       | Цалингийн өглөг   | 8,139,618,248.68             | 7,384,779,844.94             |
| 2.1.1.3       | Татварын өр   | 62,929,482,678.46            | 194,735,267,349.00           |
| 2.1.1.5       | Богино хугацаат зээл  | 330,000,000,000.00           | 125,108,417,228.17           |
| 2.1.1.6       | Хүүгийн өглөг   | 150,630,136.98               | 15,901,996,701.41            |
| 2.1.1.8       | Урьдчилж орсон орлого   | 339,534,363,656.66           | 892,864,902,375.21           |
| 2.1.1.9       | Нөөц /өр төлбөр/  | 426,555,781.00               | 34,519,180,205.47            |
| 2.1.1.10      | Бусад богино хугацаат өр төлбөр   | 3,948,674,481.00             | 2,817,769,320.00             |
|               | <b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>   | <b>1,115,148,652,680.61</b>  | <b>1,415,927,437,481.13</b>  |
| <b>2.1.2</b>  | <b>Урт хугацаат өр төлбөр</b>   |                              |                              |
| 2.1.2.2       | Нөөц /өр төлбөр/ УХ   | 45,516,330,455.33            | 72,272,164,038.33            |
| 2.1.2.4       | Бусад урт хугацаат өр төлбөр  | 880,188,699,600.00           | 1,572,699,786,080.00         |
|               | <b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>  | <b>925,705,030,055.33</b>    | <b>1,644,971,950,118.33</b>  |
| <b>2.2</b>    | <b>Өр төлбөрийн нийт дүн</b>  | <b>2,040,853,682,735.94</b>  | <b>3,060,899,387,599.46</b>  |
| <b>2.3</b>    | <b>Эздийн өмч</b>   |                              |                              |
| 2.3.1         | Өмч:- төрийн  | -                            | -                            |
| 2.3.2         | - хувийн  | -                            | -                            |
| 2.3.3         | - хувьцаат  | 11,196,000,000,000.00        | 11,196,000,000,000.00        |
| 2.3.9         | Хуримтлагдсан ашиг (алдагдал)   | 898,266,313,162.75           | 1,060,831,522,970.97         |
| <b>2.3.11</b> | <b>Эздийн өмчийн дүн</b>  | <b>12,094,266,313,162.70</b> | <b>12,256,831,522,971.00</b> |
| <b>2.4</b>    | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>   | <b>14,135,119,995,898.70</b> | <b>15,317,730,910,570.40</b> |



2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт   | 2020 оны 12-р сарын 31      | 2021 оны 12-р сарын 31      |
|---------------|--|-----------------------------|-----------------------------|
| 1             | Борлуулалтын орлого (цэвэр)                                      | 1,547,691,719,286.00        | 1,126,833,510,975.30        |
| 2             | Борлуулалтын өртөг   | (672,708,908,139.94)        | (437,355,124,872.53)        |
| <b>3</b>      | <b>Нийт ашиг( алдагдал)</b>                                      | <b>874,982,811,146.06</b>   | <b>689,478,386,102.77</b>   |
| 4             | Түрээсийн орлого   | 157,969,393.97              | 185,741,087.00              |
| 5             | Хүүгийн орлого   | 24,164,215,030.72           | 1,983,107,838.09            |
| 6             | Ногдол ашгийн орлого   | -                           | -                           |
| 7             | Эрхийн шимтгэлийн орлого   | -                           | -                           |
| 8             | Бусад орлого   | 4,558,617,764.42            | 36,162,912,582.63           |
| 9             | Борлуулалт, маркетингийн зардал                                  | (324,315,459,019.11)        | (321,496,485,327.79)        |
| 10            | Ерөнхий ба удирдлагын зардал                                     | (18,039,329,034.40)         | (22,173,005,708.40)         |
| 11            | Санхүүгийн зардал  | (10,415,287,671.24)         | (61,402,634,001.20)         |
| 12            | Бусад зардал   | (307,601,163,518.70)        | (157,861,572,128.99)        |
| 13            | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)                       | 1,545,561,030.44            | (560,774,624.94)            |
| 14            | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)                       | (11,368,945.02)             | -                           |
| 15            | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)                     | -                           | -                           |
| 16            | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)                  | -                           | -                           |
| 17            | Бусад ашиг ( алдагдал)   | -                           | -                           |
| <b>18</b>     | <b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>                     | <b>245,026,566,177.14</b>   | <b>164,315,675,819.18</b>   |
| 19            | Орлогын татварын зардал  | (96,007,989,035.72)         | (53,554,637,200.01)         |
| <b>20</b>     | <b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>                           | <b>149,018,577,141.42</b>   | <b>110,761,038,619.17</b>   |
| <b>21</b>     | <b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b> |                             |                             |
| <b>22</b>     | <b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>                       | <b>149,018,577,141.42</b>   | <b>110,761,038,619.17</b>   |
| <b>23</b>     | <b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>                                  |                             |                             |
| 23.1          | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү                      |                             |                             |
| 23.2          | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү                               |                             |                             |
| 23.3          | Бусад олз (гарз)   |                             |                             |
| <b>24</b>     | <b>Орлогын нийт дүн</b>  | <b>1,576,572,521,475.11</b> | <b>1,165,165,272,483.03</b> |
| <b>25</b>     | <b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>               | <b>12.42</b>                | <b>9.23</b>                 |

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

| №         | Үзүүлэлт   | Өмч                          | Хуримтлагдсан ашиг          | /төгрөгөөр/<br>Нийт дүн      |
|-----------|--|------------------------------|-----------------------------|------------------------------|
|           |  |                              |                             |                              |
| <b>1</b>  | <b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>                             | <b>11,196,000,000,000.00</b> | <b>1,833,918,643,628.80</b> | <b>13,029,918,643,628.80</b> |
| 2         | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | -                            | (4,670,907,607.47)          | (4,670,907,607.47)           |
| <b>3</b>  | <b>Залруулсан үлдэгдэл</b>   | -                            | -                           | -                            |
| 4         | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)                                    | -                            | 149,018,577,141.42          | 149,018,577,141.42           |
| 5         | Бусад дэлгэрэнгүй орлого   | -                            | -                           | -                            |
| 6         | Өмчид гарсан өөрчлөлт  | -                            | -                           | -                            |
| 7         | Зарласан ногдол ашиг   | -                            | (1,080,000,000,000.00)      | (1,080,000,000,000.00)       |
| 8         | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн                              | -                            | -                           | -                            |
| <b>9</b>  | <b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>                             | <b>11,196,000,000,000.00</b> | <b>898,266,313,162.75</b>   | <b>12,094,266,313,162.70</b> |
| 10        | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | -                            | 51,804,171,189.05           | 51,804,171,189.05            |
| 11        | Залруулсан үлдэгдэл  | -                            | -                           | -                            |
| 12        | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)                                    | -                            | 110,761,038,619.17          | 110,761,038,619.17           |
| 13        | Бусад дэлгэрэнгүй орлого   | -                            | -                           | -                            |
| 14        | Өмчид гарсан өөрчлөлт  | -                            | -                           | -                            |
| 15        | Зарласан ногдол ашиг   | -                            | -                           | -                            |
| 16        | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн                              | -                            | -                           | -                            |
| <b>17</b> | <b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>                             | <b>11,196,000,000,000.00</b> | <b>1,060,831,522,970.97</b> | <b>12,256,831,522,971.00</b> |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| /төгрөгөөр/   |   |                             |                             |
|---------------|---|-----------------------------|-----------------------------|
| Мөрийн дугаар | Үзүүлэлт  | 2020 оны 12-р сарын 31      | 2021 оны 12-р сарын 31      |
| <b>1</b>      | <b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>                          | -                           | -                           |
| <b>1.1</b>    | <b>Мөнгөн орлогын дүн (+)</b>   | <b>1,003,642,059,120.93</b> | <b>1,042,006,597,515.88</b> |
| 1.1.1         | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого                          | 988,070,461,440.28          | 1,027,134,027,640.17        |
| 1.1.2         | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө                                | 31,869,691.90               | 49,661,359.20               |
| 1.1.3         | Бусад мөнгөн орлого   | 15,539,727,988.75           | 14,822,908,516.50           |
| <b>1.2</b>    | <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>  | <b>1,002,174,567,014.51</b> | <b>949,818,234,274.43</b>   |
| 1.2.1         | Ажиллагчдад төлсөн  | 47,613,170,664.71           | 47,001,245,774.21           |
| 1.2.2         | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн                                | 12,405,000,000.00           | 12,560,000,000.00           |
| 1.2.3         | Бараа материал худалдан авахад төлсөн                                 | 441,955,132,095.75          | 615,083,450,105.58          |
| 1.2.4         | Ашиглалтын зардалд төлсөн   | 28,347,908.53               | 34,439,181.64               |
| 1.2.5         | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн                 | 1,842,455,236.05            | 5,064,544,685.55            |
| 1.2.6         | Хүүгийн төлбөрт төлсөн  | 10,264,657,534.26           | 43,434,314,806.73           |
| 1.2.7         | Татварын байгууллагад төлсөн  | 471,501,128,183.36          | 207,939,560,114.26          |
| 1.2.8         | Даатгалын төлбөрт төлсөн  | 275,716,022.40              | 359,156,339.84              |
| 1.2.9         | Бусад мөнгөн зарлага  | 16,288,959,369.45           | 18,341,523,266.63           |
| <b>1.3</b>    | <b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>             | <b>1,467,492,106.42</b>     | <b>92,188,363,241.45</b>    |
| <b>2</b>      | <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>              |                             |                             |
| <b>2.1</b>    | <b>Мөнгөн орлогын дүн (+)</b>   | <b>7,401,671,535.85</b>     | <b>1,677,107,838.19</b>     |
| 2.1.1         | Хүлээн авсан хүүгийн орлого   | 7,401,671,535.85            | 1,677,107,838.19            |
| <b>2.2</b>    | <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>  | <b>157,174,176,606.09</b>   | <b>665,097,096,099.57</b>   |
| 2.2.1         | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                                   | 21,236,670,238.59           | 29,306,772,810.00           |
| 2.2.2         | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн                                 | 2,930,906,367.50            | 2,930,330,478.76            |
| 2.2.3         | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн                                 | 6,600,000.00                | -                           |
| 2.2.4         | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа                                  | 133,000,000,000.00          | 632,859,992,810.81          |
| <b>2.3</b>    | <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b> | <b>(149,772,505,070.24)</b> | <b>(663,419,988,261.38)</b> |
| <b>3</b>      | <b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>                      |                             |                             |
| <b>3.1</b>    | <b>Мөнгөн орлогын дүн (+)</b>   | <b>542,000,000,000.00</b>   | <b>761,414,292,273.95</b>   |
| 3.1.1         | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан                   | 542,000,000,000.00          | 761,414,292,273.95          |
| <b>3.2</b>    | <b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>  | <b>923,555,170,360.00</b>   | <b>274,823,269,709.61</b>   |
| 3.2.1         | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө                          | 743,725,000,000.00          | 274,823,269,709.61          |
| 3.2.2         | Төлсөн ногдол ашиг  | 179,830,170,360.00          | -                           |
| <b>3.3</b>    | <b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>         | <b>(381,555,170,360.00)</b> | <b>486,591,022,564.34</b>   |
| 4             | Валютын ханшийн зөрүү   | 8,079,984,105.20            | (757,059,864.72)            |
| <b>5</b>      | <b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>                                       | <b>(521,780,199,218.62)</b> | <b>(85,397,662,320.31)</b>  |
| <b>6</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>               | <b>656,360,016,783.45</b>   | <b>134,579,817,564.83</b>   |
| <b>7</b>      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>              | <b>134,579,817,564.83</b>   | <b>49,182,155,244.52</b>    |

**2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

| №        | Үзүүлэлтүүд   | Хэмжих нэгж  | 2020 оны гүйцэтгэл (ЭТТМ багтсан) | 2021 он            |                    |                    |             |
|----------|---|--------------|-----------------------------------|--------------------|--------------------|--------------------|-------------|
|          |   |              |                                   | Жилийн төсөв       | Гүйцэтгэл          | Зөрүү              | Хувь        |
| А        | Б   | В            | 1                                 | 2                  | 3                  | 4                  | 5           |
| <b>1</b> | <b>Олборлолт, борлуулалт</b>  |              |                                   |                    |                    |                    |             |
|          | Борлуулах нүүрсний хэмжээ   | мян.тн       | 11,905.8                          | 11,752.8           | 6,328.0            | -5,424.8           | 53.8        |
|          | Борлуулах нүүрсний үнэ  | \$/тонн      | 49.7                              | 59.8               | 62.6               | 2.8                | 104.7       |
|          | Хатуу коксжих нүүрс   | \$/тонн      | 50.9                              | 60.1               | 65                 | 4.9                | 108.2       |
|          | Хатуу коксжих нүүрс - DAP   | \$/тонн      | -                                 | 118.1              | 206.5              | 88.4               | 174.9       |
|          | Сул коксжих нүүрс   | \$/тонн      | 0                                 | 53.1               | 0                  | -53.1              | 0.0         |
|          | Исэлдсэн, эрчим хүчний нүүрс  | \$/тонн      | 9.8                               | 8.7                | 10.4               | 1.7                | 119.5       |
|          | Уулын цул   | мян.м3       | 85,160.3                          | 76,642.8           | 57,920.5           | -18,722.3          | 75.6        |
|          | Хөрс хуулалт  | мян.м3       | 75,829.6                          | 67,205.7           | 51,870.5           | -15,335.2          | 77.2        |
|          | Нүүрс олборлолт   | мян.тн       | 13,129.0                          | 13,260.6           | 8,598.5            | -4,662.1           | 64.8        |
|          | Хөрс хуулалтын коэффициент  | м3/тн        | 5.8                               | 5.1                | 6.1                | 1.0                | 119.6       |
| <b>2</b> | <b>Нийт орлого</b>  | <b>сая.₮</b> | <b>1,706,779.1</b>                | <b>2,005,451.6</b> | <b>1,165,165.3</b> | <b>-840,286.3</b>  | <b>58.1</b> |
|          | Үүнээс: цэвэр борлуулалт  | сая.₮        | 1,677,607.7                       | 2,004,416.1        | 1,126,833.5        | -877,582.6         | 56.2        |
| <b>3</b> | <b>Нийт зардал</b>  | <b>сая.₮</b> | <b>1,461,143.9</b>                | <b>1,696,003.5</b> | <b>860,942.3</b>   | <b>-835,061.2</b>  | <b>50.8</b> |
|          | <b>Үйл ажиллагааны зардал</b>   | <b>сая.₮</b> | <b>1,162,517.8</b>                | <b>1,634,176.4</b> | <b>842,817.7</b>   | <b>-791,358.7</b>  | <b>51.6</b> |
|          | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг   | сая.₮        | 746,564.9                         | 940,310.1          | 437,355.1          | -502,955.0         | 46.5        |
|          | Борлуулалт, ачилтын зардал /АМНАТ багтсан/  | сая.₮        | 354,068.7                         | 545,594.5          | 321,496.5          | -224,098.0         | 58.9        |
|          | Удирдлагын зардал   | сая.₮        | 22,486.2                          | 22,829.9           | 22,173.0           | -656.9             | 97.1        |
|          | Хайгуул үнэлгээний зардал   | сая.₮        | 8,973.4                           | 3,811.6            | 390.5              | -3,421.1           | 10.2        |
|          | IPO-той холбоотой гэрээт ажлын хөлс   | сая.₮        | 20,009.4                          | -                  | -                  | -                  |             |
|          | Санхүүгийн зардал   | сая.₮        | 10,415.3                          | 121,630.4          | 61,402.6           | -60,227.8          | 50.5        |
|          | <b>Үйл ажиллагааны бус зардал</b>   | <b>сая.₮</b> | <b>7,086.8</b>                    | <b>61,827.1</b>    | <b>18,124.6</b>    | <b>-43,702.5</b>   | <b>29.3</b> |
|          | Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажлууд   | сая.₮        | 134.6                             | 28,923.90          | 1,829.20           | -27,094.7          | 6.3         |
|          | Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх ажлууд   | сая.₮        | 4,355.60                          | 1,521.40           | 776.7              | -744.7             | 51.1        |
|          | Нийгмийн хариуцлагын хүрээнд Ковид 19 цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд шаардлагатай зардлын төсөв /Вакцин, оношлуур, вирусын эсрэг эм гэх мэт/ | сая.₮        |                                   | 29,634.10          | 14,821.40          | -14,812.7          | 50.0        |
|          | Үйл ажиллагааны бус зардал  | сая.₮        | 2,596.6                           | 1,747.7            | 697.3              | -1,050.4           | 39.9        |
| <b>4</b> | <b>Бусад зардал (СТОУС-ын дагуу бүртгэсэн болон төсөвлөгдөөгүй зардлууд)</b>  | <b>сая.₮</b> | <b>291,539.3</b>                  |                    | <b>139,907.3</b>   | <b>139,907.3</b>   |             |
|          | Найдваргүй авлагын зардал   | сая.₮        | 880.0                             |                    | 10.5               | 10.5               |             |
|          | Хүү торгууль хөнгөлөлтийн зардал  | сая.₮        | 391.2                             |                    | 12,670.9           | 12,670.9           |             |
|          | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)  | сая.₮        | 1,583.6                           |                    | (560.8)            | -560.8             |             |
|          | Урт хугацаат хөрөнгө оруулалтын гарз  | сая.₮        | -                                 |                    | (390.1)            | -390.1             |             |
|          | Урт хугацаат авлагын үнэ цэнийн бууралт   | сая.₮        | 282,789.1                         |                    | 102,651.3          | 102,651.3          |             |
|          | Татварын акт  | сая.₮        | -                                 |                    | 23,084.7           | 23,084.7           |             |
|          | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз, (гарз)   | сая.₮        | (11.4)                            |                    | (539.0)            | -539.0             |             |
|          | Бараа материалын үнэ цэнийн бууралт   | сая.₮        | 9,051.2                           |                    |                    | 0.0                |             |
| <b>5</b> | <b>Татварын өмнөх ашиг</b>  | <b>сая.₮</b> |                                   | <b>309,448.1</b>   | <b>164,315.7</b>   | <b>-145,132.4</b>  | <b>53.1</b> |
|          | <b>ААНОАТ</b>   |              |                                   | <b>76,462.0</b>    | <b>53,554.7</b>    | <b>-22,907.4</b>   | <b>70.0</b> |
| <b>6</b> | <b>Ашиг алдагдал</b>  | <b>сая.₮</b> | <b>149,409.2</b>                  | <b>232,986.0</b>   | <b>110,761.0</b>   | <b>-122,225.0</b>  | <b>47.5</b> |
| <b>7</b> | <b>Улсын төсөвт төвлөрүүлэх татвар</b>  | <b>сая.₮</b> | <b>490,087.5</b>                  | <b>585,182.5</b>   | <b>420,633.6</b>   | <b>-164,548.9</b>  | <b>71.9</b> |
|          | <b>Хөрөнгө оруулалтын хэмжээ</b>  | <b>сая.₮</b> | <b>764,166.3</b>                  | <b>3,345,722.6</b> | <b>800,367.6</b>   | <b>2,545,355.0</b> | <b>23.9</b> |
|          | Үүнээс: ТТ-ГС төмөр замын хөрөнгө оруулалт  | сая.₮        | 732,939.1                         | 514,101.3          | 348,057.9          | -166,043.4         | 67.7        |
|          | Үүнээс: ТТ-ЗБ төмөр замын хөрөнгө оруулалт  | сая.₮        |                                   | 937,200.0          | 273,405.4          | -663,794.6         | 29.2        |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад балансын данстай холбоотой өглөг авлагыг барагдуулж ажиллах, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд хяналт тавих, элэгдлээр өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн бүртгэлийг шийдвэрлэх, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх зарим журмуудыг боловсруулж мөрдөх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 11-нээс 3 дугаар сарын 15-ны хооронд Гроут финанс Аудит ХХК-ийн Аудитор М.Насанбат, Т.Ариунжаргал, Ү.Цэцэгмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг тус компанийн чанарын менежер Ч.Хүнбиш, захирал Б.Бямба хэрэгжүүлсэн.

Эрдэнэс Тавантолгой ХК нь 2021 оны санхүүгийн тайлангаа 2022 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 01/265 дугаар албан бичгээр Гроут финанс Аудит ХХК-д ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газар нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн “Компанийн орон тооны хязгаар, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” 28 дугаар тогтоолоор 2 хэлтэс, 2 алба нийт 11 ажилтантай дараах бүтэц зохион байгуулалттайгаар ажилладаг.

Тайлант онд Хяналт шалгалтын хэлтэс нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд 22 ажлыг, хяналт шинжилгээ-үнэлгээний чиглэлээр 11 ажлыг, тогтмол хяналтын чиглэлээр 6 ажил, мөн өмнөх аудитын албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжилтийн явцын талаар компанийн гүйцэтгэх захиралд танилцуулсан байна.

Эрсдэлийн удирдлагын хэлтэс нь “Эрсдэлийн удирдлага”-ын чиглэлээр 12 ажил, “Зөвлөх үйлчилгээ”-ний хүрээнд компанийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах зорилгын хүрээнд эрсдэлийн удирдлагын 21 заалт бүхий 12 сарын хөтөлбөр боловсруулан компанийн ажилтнуудыг хамруулан ажилласан байна.

“Нэгдсэн менежментийн чиглэл”-ээр 8 ажил, хариуцлагатай уурхайг хөгжүүлэхээр Нэгдсэн Үндэсний Байгууллагын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”, хариуцлагатай уул уурхайтай холбоотой олон улсын 23 стандарт баримт бичгүүд, Төрөөс эрдэс баялгийн талаар баримтлах бодлогод туссаны дагуу хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилгыг дэмжин 5 бүлэг 247 асуулгатайгаар 2020 онд шалгуур үзүүлэлтийг батлуулж, энэхүү үнэлгээний сайжруулалтыг 2021 онд хийж ажилласан байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компани 2020 онд зөвлөх үйлчилгээний хүрээнд “PWC Audit” Олон улсын аудитын компаниар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” боловсруулах ажлыг гүйцэтгүүлж, компанийн гүйцэтгэх захирлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/357 дугаар тушаалаар тэрхүү бодлогын баримт бичгийг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр шийдвэрлэжээ.

Энэхүү Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба уг бодлогод байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нарийвчилсан журмуудыг баталж мөрдөхөөр заасан ч авлагын хүлээгдэж буй эрсдэлийн санг тооцоолох, урьдчилгаа төлбөр, бараа материалын бүртгэл, хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойлох зэрэг заавар, журмуудыг боловсруулаагүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалыг барьж ажилладаг гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны нийт орлогын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлогын дүн болох 1,578,118.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 15,781.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн материаллаг байдлын түвшинг аудитын гүйцэтгэлийн шатанд дахин хянаж үзэхэд тайлант хугацаанд Ковид-19 цар тахлын нөлөөнөөс нийт орлого буурсан нь аудитын ажлын цар хүрээг багасгах үндэслэл болсон тул 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,164,511.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 11,645.1 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо. Төлөвлөлтийн шатанд сонгосон материаллаг байдлын суурь болон хувь хэмжээг өөрчлөөгүй болно.



## 4. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эрдэнэс Тавантолгой ХК үйл ажиллагааны зорилгоо “Тавантолгой ордын хайгуул, судалгаа болон олборлолт, борлуулалтын үйл ажиллагаа явуулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар ашигт ажиллагааг нэмэгдүүлж, сайн чанарын үндэсний бренд бүтээгдэхүүн бий болгож, Олон улсад гаргах аюулгүй, тогтвортой, хариуцлагатай уул уурхайн аж үйлдвэрийг хөгжүүлэн улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд бодит хувь нэмэр оруулж, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгийн үр өгөөжийг хүртээхэд оршино.” гэж тодорхойлжээ.

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нүүрсний ордын хайгуул, судалгаа, борлуулалт болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, Ложистикийн үйл ажиллагаа, гаалийн хяналтын бүсэд бүтээгдэхүүн хадгалах, ачиж буулгах, тээвэрлэх;
- Ордыг ашиглахтай холбоотой боловсруулах, үйлдвэр байгуулах, шаардлагатай дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
- Бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилгоор лабораторийн үйл ажиллагаа эрхлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх;

### 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Улсын Их хурлын “Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” 2010 оны 39 дүгээр тогтоолоор Тавантолгойн нүүрсний стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг байгуулахыг үүрэг болгосны дагуу Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг Тавантолгой нүүрсний ордод ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулах үндсэн чиглэлээр байгуулж 2010 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд Хувьцаат компани гэсэн статустай байна. Компанийн эргэлтэд гаргасан энгийн хувьцааны 81.5 хувийг төр (Эрдэнэс Монгол ХХК), 18.4 хувийг Монгол Улсын 2,511,332 иргэн, 0.1 хувийг 486 аж ахуйн нэгж байгууллагууд эзэмшиж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 “төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно” гэсэн заалттай нийцэж байна. Мөн компанийн удирдлагыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгож байгаа нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 “компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох” гэсэн заалттай нийцэж байна.

Үндсэн хөрөнгийн бүртгэл хамгаалалтын чиглэлээр жил бүр Гүйцэтгэх захирлын тушаалаар үндсэн хөрөнгө бараа, материалын тооллогын комиссыг байгуулж, 12 дугаар сард компанийн салбар болон төв оффист тооллогыг явуулдаг. Жилийн эцсийн тооллогын тайлангийн дагуу ашиглалтаас гарч байгаа үндсэн хөрөнгө, бараа материалын жагсаалтыг гаргаж Захирлуудын зөвлөлийн хурал, Компанийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гаргуулан Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, Төрийн өмчийн бодлого Аудитын код: АХГ-2022/61/НА-СТА-ТӨА

зохицуулалтын газрын 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А-1/694 тоот удирдамж, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ТУЗ-ийн 23 дугаар тогтоол гарсан. Уг тогтоолоор бараа материалд бүртгэлтэй ашиглах боломжгүй болсон 68.3 сая төгрөгийн бараа материалыг акталж, 254.1 сая төгрөгийн 20 тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар борлуулах шийдвэрийн дагуу дуудлага худалдаа зохион байгуулж 176.2 сая төгрөгөөр борлуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд орсон 2021 оны нэмэлт өөрчлөлтүүд;
- Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн Газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;

Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 21/02 дугаар тогтоолоор компанийн дүрэмд 9 заалтад өөрчлөлт оруулсан.

Компанийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулсныг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх дараах журмуудыг шинэчлэн боловсруулж баталсан. Үүнд:

- Мөнгөн кассын үйл ажиллагааны журам
- Дуудлага худалдаа зохион байгуулах журам
- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам
- Төлбөрийн карт ашиглах журам
- Төв оффист автомашин ашиглах, сэлбэг хэрэгсэл, шатахуун, тос тосолгооны тооцоо хийх журам
- Интернет банкаар төлбөр тооцоог гүйцэтгэх журам
- Нягтлан бодох бүртгэлийн асуудал хариуцсан нэгжийн тайлан мэдээ хүлээн авах тайлагнах журам
- Уурхайн агуулахын нүүрсийг бүртгэх зэрэг журмуудыг шинэчлэн боловсруулсан

#### **4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого**

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.



Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл          | Эцсийн үлдэгдэл         | Өөрчлөлт               |
|---|-------------------------|-------------------------|------------------------|
| Б   | 1                       | 2                       | 3=2-1                  |
| Мөнгөн хөрөнгө                                    | 134,579,817.6           | 49,182,155.2            | (85,397,662.3)         |
| Авлага  | 34,210,383.3            | 22,416,076.8            | (11,794,306.4)         |
| Урьдчилгаа  | 898,673,489.0           | 1,613,359,984.2         | 714,686,495.2          |
| Бараа материал                                    | 129,688,069.9           | 263,756,064.8           | 134,067,994.9          |
| БЗЭБЭБХ (борлуулах бүлэг хөрөнгө)                 | 392,534.2               | (0.00)                  | (392,534.2)            |
| <b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>                    | <b>1,197,544,294.0</b>  | <b>1,948,714,281.1</b>  | <b>751,169,987.1</b>   |
| Үндсэн хөрөнгө                                    | 46,918,974.6            | 110,961,149.2           | 64,042,174.6           |
| Биет бус хөрөнгө                                  | 11,138,815,800.5        | 11,126,449,728.5        | (12,366,072.0)         |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт                     | 309,341,309.2           | 308,599,116.0           | (742,193.2)            |
| Хайгуул ба үнэлгээний хөрөнгө                     | 15,832,974.5            | 16,453,934.9            | 620,960.4              |
| Хойшлогдсон татварын хөрөнгө                      | 41,780,018.8            | 116,334,261.2           | 74,554,242.4           |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө                       | 1,384,886,624.3         | 1,690,218,439.6         | 305,331,815.3          |
| <b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>                | <b>12,937,575,701.9</b> | <b>13,369,016,629.4</b> | <b>431,440,927.6</b>   |
| <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>14,135,119,995.9</b> | <b>15,317,730,910.6</b> | <b>1,182,610,914.7</b> |
| <b>Өр төлбөрийн дүн</b>                           | <b>2,040,853,682.7</b>  | <b>3,060,899,387.6</b>  | <b>1,020,045,704.9</b> |
| Богино хугацаат өглөг                             | 1,115,148,652.7         | 1,415,927,437.5         | 300,778,784.8          |
| Урт хугацаат өглөг                                | 925,705,030.1           | 1,644,971,950.1         | 719,266,920.1          |
| Эздийн өмч  | 12,094,266,313.2        | 12,256,831,523.0        | 162,565,209.8          |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>14,135,119,995.9</b> | <b>15,317,730,910.6</b> | <b>1,182,610,914.7</b> |

Өмнөх оны үзүүлэлтүүдээс дараах дансуудын үлдэгдэлд материаллаг дүнтэй өөрчлөлтүүд гарсан байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн данс 49,182.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 9.2 сая төгрөг нь бэлэн мөнгөөр, 49,172.9 сая төгрөг нь банкны харилцах дансанд байршиж байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан гол шалтгаан нь Чингис хаан банкинд байршиж байсан 54,928.0 сая төгрөг бүхий ам.долларын болон Үндэсний хөрөнгө оруулалтын банкинд байршиж байсан 28,274.3 сая төгрөгийн үлдэгдэл бүхий харилцах дансууд төлбөр гүйцэтгэх чадвараа алдсан ба Чингис хаан банкин дахь мөнгөн хөрөнгийг төлж барагдуулах шүүхийн шийдвэр болон Үндэсний хөрөнгө оруулалтын банкт байгуулсан гэрээний дагуу дээрх мөнгөн хөрөнгийг авлагын дансанд шилжүүлэн бүртгэсэн.
- Авлага дансны үлдэгдэл 22,416.0 сая төгрөгөөс 2,641.3 сая төгрөг буюу 12 хувийг дансны авлага, 5,389.7 сая төгрөг буюу 24 хувийг татвар, шимтгэлийн авлага, 14,385.0 төгрөг буюу 64 хувийг бусад авлага тус тус эзэлж байна. Дансны авлага 22,750.5 сая төгрөгөөс 2,641.3 сая төгрөг болж буурсан нь борлуулалт буурсантай холбоотой ба тайлант хугацаанд 2013 оноос хойш үүссэн эзэн холбогдогчийн хаяг тодорхойгүй, хөөн хэлэлцэх хугацаа дуусч Шүүх хүлээн авч хэлэлцэх боломжгүй болсон үндэслэлээр БНХАУ-ын 3 компаниас авах нийт 384,126.60 ам доллар авлагыг ТУЗ-ийн 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 24 тоот тогтоолоор данснаас хасахаар шийдвэрлэсний дагуу 1,492.1 сая төгрөгийн авлагыг данснаас хассан, БНХАУ-ын Тань Ю группээс авах 1,208.0 сая төгрөгийн авлагад өнгөрсөн онд 50.0 хувь, тайлант онд үлдсэн 50.0 хувьд найдваргүй авлагын хасагдуулга тооцож бүртгэсэн байна. Татвар шимтгэлийн 5,389.7 сая төгрөгийн авлагын 3,939.4 сая төгрөг буюу 73.0 хувийг нэмэгдсэн өртгийн албан татварын авлага, 4,342.8 сая төгрөг буюу 25.0 хувийг хувь хүний орлогын албан татварын авлага (өмнөх жилийн ноогдол ашгийн татварын тооцооноос үүссэн), 107.5 сая төгрөг буюу 2.0 хувийг нийгмийн даатгалын шимтгэл болон ус ашигласны төлбөрийн илүү төлөлтөөс үүссэн авлага эзэлж байна.

Бусад авлагын үлдэгдэл 14,385.3 сая төгрөг болж өмнөх оноос 5,851.0 сая төгрөгөөр буюу 17 хувиар өссөн нь Үндэсний хөрөнгө оруулалтын банкинд байршиж байсан мөнгөнөөс тайлант хугацааны эцэст төлөгдөөгүй үлдэгдэл 11,974.2 сая төгрөгийг авлагын дансанд нэмж бүртгэн, Багануур ХК-тай байгуулсан гэрээний дагуу Эрдэнэс Монгол ХХК-аас авах 6,660.4 сая төгрөгийн авлагыг хасч, урт хугацаат авлага рүү шилжүүлэн бүртгэснээс голлон нөлөөлжээ.

- Урьдчилгаа төлбөр дансны үлдэгдэл 1,613,359.9 сая төгрөг байна. Үүнээс 1,081,317.7 сая төгрөг буюу 66 хувь нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын, 406,405.4 сая төгрөг буюу 25 хувь нь Зүүнбаян чиглэлийн төмөр замын санхүүжилтийн урьдчилгаа төлбөрүүд нийт урьдчилгааны 91 хувийг эзэлж байна. Мөн түүнээс гадна “Тавантолгой нүүрс ачилт логистикийн төв”-ийн санхүүжилтийн урьдчилгаа 78,800.0 сая төгрөг, Тавантолгой дулааны станцын санхүүжилтийн урьдчилгаа 5,692.6 сая төгрөг, нүүрс баяжуулах болон усны төслүүдийн урьдчилгаа 7,826.9 сая төгрөг, бонд гаргалттай холбоотой зардлыг хуримтлуулан бүртгэсэн 5,825.7 сая төгрөг, өмнөх оны үйл ажиллагаанаас үүссэн 42,311.3 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр байна. Урьдчилгаа төлбөрийн дүн өмнөх оноос 714,686.5 сая төгрөг буюу 81 хувиар өссөн нь тайлант хугацаанд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын санхүүжилтэд 348,378.6 сая, Зүүнбаян чиглэлийн төмөр замын санхүүжилтэд 273,405.4 сая, Тавантолгой дулааны станцын төсөлд 5,692.6 сая, Тавантолгой нүүрс ачилт логистикийн төвийн санхүүжилтэд 81,021.6 сая төгрөг нэмж олгосонтой холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 263,756.1 сая төгрөг болж 134,067.0 сая төгрөгөөр өссөн байна. Бараа материалын дансны нийт үлдэгдлийн 97.0 хувь 255,854.6 сая төгрөгийн 6.2 сая тонн нүүрс эзэлж байна. Өмнөх онд исэлдсэн нүүрсний цэвэр боломжит үнэ цэнэ, өртгөөс бага болсон үед бараа материалын дансны үлдэгдэлд 20,345.7 сая төгрөгийн үнэ цэнийн бууралт тооцож хасагдуулга бүртгэсэн байсныг тайлант онд буцаах бичилт хийсэн нөлөөллөөр бараа материалын дансны үнэ нэмэгдсэн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 110,961.1 сая төгрөг буюу 136.0 хувиар өссөн нь компани өөрөө олборлолт хийх зорилгоор 61,838.1 сая төгрөгийн 17 ширхэг машин, механизм худалдаж авсантай холбоотой байна. Үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ өртгөө нөхсөн 3,875.3 сая төгрөгийн анхны өртөг бүхий 2,368 ширхэг хөрөнгө байна. Дуусаагүй барилга данс 17,391.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь цанхийн зүүн уурхайн оффисын барилга болон ажилчдын орон сууцны барилга баригдаж дуусаагүй байна. Дээрх барилгуудыг тайлант хугацаанд барьж дуусгахаар төлөвлөн ажиллаж байсан боловч Ковид 19 цар тахлын улмаас хил хааж барилгын материалын нийлүүлэлт зогссоноос хугацаандаа ашиглалтад ороогүй байна.
- Тайлант онд охин болон хараат компаниудад оруулсан хөрөнгө оруулалт 309,341.3 сая төгрөгөөс 308,599.1 сая төгрөг болж 742.2 сая төгрөгөөр буурсан нь Засгийн газрын шийдвэрээр Тавантолгой Түлш ХХК-д оруулсан 0.5 сая төгрөгийн хөрөнгийг шинээр бүртгэж, Гашуун сухайтын төмөр зам ХХК болон Тавантолгой Төмөр зам ХХК-ийн хөрөнгө оруулалтыг 742.7 сая төгрөгөөр бууруулж залруулснаас шалтгаалжээ.
- Бусад эргэлтийн бус хөрөнгө дансанд тайлант хугацааны эцэст 1,690,218.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас уурхайн хөрс хуулалтын хөрөнгө 955,493.3 сая төгрөг, уурхайн бүтээн байгуулалтыг капиталжуулсан зардал 8,277.3 сая төгрөг, урт хугацаат авлага (хасагдуулга тооцсон дүнгээр) 726,416.0 сая төгрөг, бусад урт хугацаат авлага 31.8 сая төгрөг байна. Үүнээс урт хугацаат авлага дансанд Эрдэнэс Монгол ХХК-ийн 61,442.4 сая төгрөг, Монголын төмөр зам ХХК-ийн 750,000.0 сая төгрөг, Тавантолгой Түлш ХХК-ийн 449,920.1 сая төгрөг, Багануур ХК(Эрдэнэс Монгол ХХК-ийн төлөх)-ийн 14,400.4 сая төгрөг, Чингис хаан банкны 54,709.6 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Дээрх байгууллагуудын авлагад нийт 604,056.5 сая төгрөгийн хасагдуулга тооцож урт хугацаат авлагын бодит үнэ цэнийг 726,416.0 сая төгрөгөөр илэрхийлсэн байна.

- Хайгуул үнэлгээний хөрөнгө дансны үлдэгдэл 16,453.9 сая болж өссөн нь тайлант онд 654.5 сая төгрөгийн хайгуулын зардал гарснаас 620.9 сая төгрөгийн хайгуул үнэлгээний хөрөнгөд бүртгэж, 33.6 сая төгрөгийг тайлант хугацаанд гарсан хайгуулын зардал болгосон.
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 1,415,927.4 сая төгрөгийн өр төлбөр байна. Урт хугацаат өр төлбөр дансанд 2019 онд зарласан ноогдол ашгийн улсад ноогдох хэсэг 880,188.7 сая төгрөг, 2021 онд үнэт цаасны зах зээл дээр гаргасан 2 жилийн хугацаатай бондын өр төлбөр 692,511.1 сая төгрөг, нийт 1,644,971.9 сая төгрөгийн өр төлбөр байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал, бусад зардал гэж ангилсан байна. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг тайлант онд 437,355.1 сая төгрөг болж өмнөх оноос 235,353.8 сая төгрөгөөр буурсан нь Ковид 19 цар тахлын нөлөөгөөр хил хаагдаж, нүүрсний экспорт зогссоноос борлуулалт багассантай холбоотой байна. Үүнтэй уялдан борлуулалт маркетингийг зардал 321,496.5 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 2,819.0 сая төгрөгөөр буурсан байна. Ерөнхий удирдлагын зардал 22,173.0 сая төгрөг болж өмнөх оноос 4,133.7 сая төгрөгөөр нэмэгдсэн ба зардлын өсөлтөд цалин болон нийгмийн даатгалын шимтгэл, тэтгэмж, хөдөлмөр хамгаалал, элэгдлийн зардлууд гол нөлөө үзүүлсэн байна.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу байгууллага үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Компани 2021 онд Цанхийн уурхай болон Бортээгийн уурхайгаас нийт 11.7 сая тонн нүүрс олборлон борлуулж, 703.3 сая ам.долларын орлоготой ажиллахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 6.3 сая тонн нүүрс борлуулж, 396.1 сая ам.долларын борлуулалтын орлоготой ажилласнаар гүйцэтгэл нүүрсний хэмжээгээр 54.0 хувь, мөнгөн дүнгээр 56.0 биелэлттэй байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 31 өдрийн 49 дугаар тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан. Уг тогтоолоор нийт орлогыг 2,674,586.6 сая, нийт зардлыг 1,954,226.8 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтад 2,454,122.0 сая төгрөг зарцуулахаар баталсан. Төлөөлөн Удирдах зөвлөл нь 2021 оны зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 2021 оны 39, 45 дугаар тогтоолоор тус тус өөрчлөлт оруулж тодотгол хийжээ. Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 29 өдрийн 45 дугаар тогтоолоор нийт орлогыг 2,005,451.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,696,003.5 сая төгрөгөөр, 309,448.1 сая төгрөгийн ашигтай байхаар, хөрөнгө оруулалтыг 3,345,722.6 сая төгрөгөөр шинэчлэн баталсан байна.

2021 оны гүйцэтгэлээр 1,165,165.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,000,849.6 сая төгрөгийн зардал гарган, 164,315.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Тайлант онд орлогын албан татварт 53,554.7 сая төгрөгийг төлөхөөр тооцоолсон байна.

Нийт орлогыг 2,005,451.6 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,165,165.3 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 840,286.3 сая төгрөг буюу 58.0 хувиар тасарсан нь дэлхий нийтээр тархаад буй Ковид 19 цар тахлын улмаас Улсын онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/422 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс Тавантолгой-Цагаанхад чиглэлийн уртын тээврийг 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс тодорхойгүй хугацаагаар түр зогсоосон нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардал нь гүйцэтгэлээр 860,942.3 сая төгрөг (СТОУС-ын дагуу бүртгэсэн болон төсөвлөгдөөгүй зардлуудыг оруулаагүй) болж, төлөвлөснөөс 835,061.2 сая төгрөг буюу 50.8 хувиар дутуу зарцуулагдсан байна. Энэ нь Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хил хаагдаж, Цагаанхад дахь агуулахын талбай дүүрсэн зэргээс шалтгаалан Цанхын баруун, зүүн, Бортээгийн уурхайн төлөвлөгөө бүрэн биелээгүй тул үндсэн үйл ажиллагааны зардлыг 791,256.3 сая төгрөгөөр, үйл ажиллагааны бус зардлыг 43,702.5 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна. Засгийн газрын 43 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын А-1/354 тоот албан даалгавар болон компанийн бодлогын хүрээнд Ковид-19 цар тахлын үед зардлыг хэмнэх чиглэлийг баримтлан ажилласан байна.

Тайлант онд татварын дараах байдлаар 232,986.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 110,761.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

## **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Гэвч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 03/2653 дугаар албан бичиг, гүйцэтгэх захирлын тушаалын дагуу Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д хамаарах мэдээллийг нэмж мэдээлэхээр шийдвэрлэсэн.

Тайлант онд 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 1,805,697.2 сая төгрөгийн, зарлагын 1,774,995.9 сая төгрөгийн гүйлгээг мэдээлж, Шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулах 66 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Худалдан авалттай холбоотой 115 мэдээлэл оруулахаас 20 мэдээллийн үнийн дүн зөрүүтэй, хөрөнгө оруулалт тендертэй холбоотой 106 мэдээлэл оруулснаас 12 мэдээллийг давхардуулан оруулсан байна. Шилэн дансны хэрэгжилт 96.0 хувийн гүйцэтгэлтэй гэж үзлээ.

### **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилын үр дүнд үндэслэн дараах асуудлуудыг тодрууллаа.

1.Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үзэхэд дараах байдалтай байна.

Гүйцэтгэх захирлын шийдвэрээр А6/20 төлөвлөгөөг амжилттай боловсруулсан ажлын хэсэгт ажилласан ажилтнуудад 128.0 сая төгрөгийн, Хамтын гэрээнд заасны дагуу жилийн ажлын үр дүнгээр ажилчдад 6,020.4 сая төгрөгийн урамшуулал олгосон нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин

хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаарх тогтоолыг хэрэгжүүлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх;

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй, босго үнээс давсан 301.2 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон босго үнийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

## **6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудитаар 335,223.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 28.1 сая төгрөгийг залруулж, 184,975.9 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 150,219.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 52,734.0 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, бусад алдаа зөрчилд 4 зөвлөмж өгснөөс албан шаардлага 50.0 хувь, зөвлөмж 80.0 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 2.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт        | /сая төгрөг/        |          |         |     |       |          | Хувь |
|-----------------|---------------------|----------|---------|-----|-------|----------|------|
|                 | Өмнөх оны илрүүлэлт |          | Биелэлт |     | Зөрүү |          |      |
|                 | Тоо                 | Дүн      | Тоо     | Дүн | Тоо   | Дүн      |      |
| Албан шаардлага | 2                   | 52,734.0 | 1       | -   | 1     | 52,734.0 | 50.0 |
| Зөвлөмж         | 4                   | -        | 3       | -   | 1     | -        | 80.0 |
| Нийт дүн        | 6                   | 52,734.0 | 4       | -   | 2     | 52,734.0 | 66.6 |

Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д. “Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” заалтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагын биелэлт хангалтгүй, алдаа, зөрчил давтан гарсан асуудалд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбоотой “Нөөц болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө” стандартыг мөрдөж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.



## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар анхаарал татсан доорх асуудлуудыг дараагийн аудитаар шалгахаар шийдвэрлэлээ. Үүнд:

а/ Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 135 дугаар тогтоолын дагуу Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор нэг удаагийн, хүүгүй, 20 хүртэл жилийн хугацаатай үнэт цаасыг нэрлэсэн үнээр хаалттай хүрээнд худалдах эрхийг Монголын төмөр зам ХХК-д өгсөн. Уг үнэт цаасыг нүүрс тээвэрлэлтийн төлбөрөөс суутган эргэн төлөгдөх нөхцөлөөр Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хуримтлагдсан ашгаас худалдан авах тухай шийдвэр гарсан боловч энэ хөрөнгийг Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын хөрөнгө оруулалтад оруулан тооцох эсэх нь тодорхойгүй, холбогдох шийдвэрүүд нь гараагүй байна.

б/ Цанхын баруун уурхайн хөрс хуулалтын коэффициент техник эдийн засгийн үндэслэлд тусгаснаар 2021 онд 4.84 м3/тн байхаар тооцооллыг хийсэн боловч тайлант онд уулын ажлын тайлангаар 8.71 м3/тн, цанхын зүүн уурхайд техник эдийн засгийн үндэслэлээр 4.83 м3/тн байхаар тооцоолсноос уулын ажлын тайлангаар 3.3 м3/тн байна. Цанхын баруун уурхайн хөрс хуулалтын коэффициент өндөр байгаа нь 2021 онд Ковид-19 цар тахлын нөлөөнөөс нүүрсний экспорт зогсож, уурхайн талбай дахь агуулахууд дүүрсэн тул уулын ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан нүүрс олборлолтыг түр хугацаанд хойшлуулж зөвхөн хөрс хуулах ажил хийснээс шалтгаалсан байна. 2021 оны эцэст цанхын баруун уурхайн талбайд хөрсийг нь хуулж олборлолт хийхэд бэлэн болгосон 500.0 мянган тонн нүүрсийг 2022 оны эхний улиралд олборлох үед хөрс хуулах зардал гарахгүй ба хөрс хуулалтын коэффициентийг хамгийн бага түвшинд барихаар төлөвлөсөн байна.

в/ Тавантолгойн ордын дунд хэсэгт байрлах Тавантолгой ХХК нүүрс олборлолтын явцдаа уурхайн хилийг давж Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ордоос нүүрс олборлосон нь тогтоогдсон. Үүнийг 2 талаас комисс гарч Эрдэнэс Тавантолгой ХК-ийн уурхайн талбайгаас олборлосон нүүрсний хэмжээг эхний ээлжинд 268.0 мянган тонн гэж тогтоон акт үйлдсэн байна. Тайлант хугацаанд 52.0 мянган тонн нүүрсийг Тавантолгой ХХК-аас хүлээн авсан бөгөөд үлдсэн хэсгийг нүүрсний илчлэг шаардлагад нийцэхгүй байгаа гэдэг шалтгаанаар аваагүй байна. Одоогоор хүлээж аваагүй байгаа нүүрсний үнэ цэнийг ямар өртөг, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгах нь тодорхойгүй, шийдвэрлэгдээгүй байгаа тул авлагаар бүртгэж тайланд тусгаагүй байна.

г/ Экспортод гаргаж байгаа коксжих нүүрсэнд тооцох Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тооцохдоо Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн дугаар зүйлийн 47.2.1-д заасан “экспортод бүтээгдэхүүн гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлана” гэж заасан. Гэтэл Засгийн газрын 2019 оны 465 дугаар тогтоолоор батлагдсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ын 2.4-т “Гадаадын зах зээлд борлуулж байгаа бүх төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүний агуулга, түүний хувь, шинж чанар, ангиллыг Гаалийн лабораторийн дүгнэлтэд үндэслэн тодорхойлно” гэж заасан. Аудитын явцад АМНАТ-ийг хуулийн дагуу давтан тооцоолоход 32.0 тэрбум төгрөгийн зөрүү үүссэн ба уг зөрүүг хуулийн тогтоомжийн дээрх зөрүүтэй байдалтай холбон тайлбарлаж, цаашид шийдвэрлүүлэхээр Татварын байгууллагатай хамтран ажиллаж журам заавар, стандартад өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг гарган ажиллаж байна.

д/ ЭТТ бондын 3-р транчийг олон улсын хөрөнгийн зах зээл дээр гаргахаар бэлтгэл ажил явагдаж байна. Хүлээн авсан бондын нийт хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр

өгөөжтэй ашиглаж байгаа эсэхийг хянах зэрэг асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 26,551.7 сая төгрөгийн 15 алдаа, зөрчил илэрснээс 19,900.8 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 2,714.7 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 3,936.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 6,650.9 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 11,645.1 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 4,994.2 сая төгрөгөөр бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

### 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 19,900.8 сая төгрөгийн 4 алдааг залрууллаа. Үүнд:

1. Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ өртгөөс өндөр болсон үед бараа материалын үнэ цэнийн бууралтыг 685.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн;
2. Тавантолгой төмөр зам ХХК-ийн хөрөнгө оруулалтын дүнд 14,819.7 сая төгрөгийн хүүгийн орлогыг тооцож бүртгэсэн;
3. Богино хугацаатай түрээсийн гэрээг урт хугацаанд түрээслэх хөрөнгөтэй адилтган 4,206.6 сая төгрөгийн ашиглах эрхтэй хөрөнгө бүртгэж, элэгдэл болон хүүгийн зардал тооцсон;
4. Дээрх бүртгэлийн алдаатай холбоотойгоор татварын зардлыг дахин тооцоолж 189.0 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр үүссэнийг хоорондын зөрүүг залрууллаа.

### 8.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд Төлөөлөн Удирдах Зөвлөл дэх төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 5 гишүүнд цалин хөлсний хэмжээг тогтоосон хязгаараас 32.8 сая төгрөгөөр илүү тооцож олгосон, өмнөх аудитаар өгсөн зөрчлийг арилгах албан шаардлагыг биелүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д. “Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

2. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тиан Юу Групп /Tian YU Group/ компаниас авах 2015 онд үүссэн нүүрсний борлуулалтын 1,208.0 төгрөгийн авлага барагдуулалт удааширч, тайлант хугацаанд 100 хувь найдваргүй авлага болгон бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг биелүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын төлбөр тооцоог хянаж, хууль хяналтын байгууллагад шилжүүлж, барагдуулах арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлсэн.

3. Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс Тавантолгой ХК, Шивээ овоо ХК-ийн 2018 оны ЭМГЛ-095/СГ-009/20180605, ЭТТ-2018/17 дугаартай Зээлийн санхүүжилт олгох гэрээний дагуу Аудитын код: АХГ-2022/61/НА-СТА-ТӨА

Шивээ овоо ХК-д олгосон зээл болон хүүгийн төлбөр 1,473.8 төгрөгийг төлөөгүй, Эрдэнэс Монгол ХХК гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, дээрх гэрээний 4.2-т заасан Эрдэнэс Тавантолгой ХК нь гэрээний хэрэгжилтийг хангуулах зорилгоор Эрдэнэс Монгол ХХК-аас гэрээний биелэлт, хэрэгжилтийг хангуулахыг шаардах эрхтэй” гэж заасныг биелүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын төлбөр тооцоог барагдуулах, гэрээний биелэлт, хэрэгжилтийг хангуулах албан шаардлага хүргүүлсэн.

4. Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбоотой өнөөгийн үүрэг хариуцлагыг бүртгэж тайлагнахдаа НББОУС 37 “Нөөц болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө” стандартыг мөрдөж ажиллах талаар өмнөх оны аудитаар зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт;” 4.2 “Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг хуульд нийцүүлэн санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоож, нийтэд мэдээлнэ. Энэ ангилалд доор дурдсан аж ахуйн нэгж, байгууллагыг заавал хамруулна;”, 4.2.4 “төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж;” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Уурхайн нөхөн сэргээлтийн нөөц сан байгуулах журмыг боловсруулж, үйл ажиллагаанд мөрдөж ажиллах

### **8.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. *Балансын данстай холбоотой асуудал***

##### Илрүүлэлт:

Үндэсний хөрөнгө оруулалтын банкны төлбөрийн чадвар буурснаас төгрөгийн харилцах дансанд байршиж байсан 28,174.2 сая төгрөгөөр төлбөр гүйцэтгэх боломжгүй болсон. Үүнийг 2021 онд багтаан төлүүлэхээр хуваарь гарган 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр ЭТТ-2021/53 тоот гэрээ байгуулсан боловч 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 11,974.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйл “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5. заалт “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэсэн заалтыг зөрчсөн.

##### Өгсөн зөвлөмж:

Мөнгөн хөрөнгийг байршуулах банкныг төлбөрийн чадварын үзүүлэлтийг харгалзан үзэж сонгож байх, үлдэгдэл төлбөрийг эхний хагас жилд багтаан барагдуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

#### **2. *Балансын данстай холбоотой асуудал***

##### Илрүүлэлт:

Эрдэнэс Тавантолгой Майнинг ХХК-аас 2020 онд шилжиж ирсэн болон бусад аж ахуй нэгжид төлөх нийт 3,141.6 сая төгрөг өглөгийн дансанд бүртгэлтэй, тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, бодитой эсэх нь нотлогдохгүй байна.



Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж өглөгийг баталгаажуулах, хэрэв гэрээний үүргээс чөлөөлөгдсөн бол тус өглөгүүдийг тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгах, өглөгийн дансыг үнэн зөв илэрхийлэх;

**3. *Балансын данстай холбоотой асуудал***

**Илрүүлэлт:**

2019 онд зөвлөх үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 2 компанитай ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулан 794.5 сая төгрөгийн урьдчилгаа олгосон байна. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй, гэрээг дүгнээгүй, барагдуулах тодорхой арга хэмжээ аваагүй, урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1."аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална; ...5.1.3.жинхэнэ хэрэгжилтийн зарчим, 5.1.4.үнэн зөв байх зарчмуудыг баримтлаагүй," 6 дугаар зүйлийн 6.1."Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө;" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үрэг, нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Дээрх байгууллагуудтай хийсэн гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, гэрээг дүгнэж, тооцоо нийлэн, гэрээг үргэлжлүүлэх шаардлагагүй бол төлбөрийг буцаан төлүүлэх арга хэмжээ авах;

**4. *Балансын данстай холбоотой асуудал***

**Илрүүлэлт:**

Тайлант хугацааны эцэст ашиглалтад байгаа үлдэх өртөггүй 3,875.2 сая төгрөгийн анхны өртөг бүхий биет болон биет бус хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлоогүй, бодит үнэ цэнээр илэрхийлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 5.1.5."хэмжигдэхүйц байх" зарчмуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн биет болон биет бус хөрөнгүүд нь цаашид ашиглагдахаар бол дахин үнэлэх асуудлыг шийдвэрлэх;

**5. *Балансын данстай холбоотой асуудал***

**Илрүүлэлт:**

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн зарцуулалтын тайланд үндэслэн санхүүжилтийг олгох гэрээний заалтыг мөрдөж ажиллаагүй, төслийн санхүүжилтийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

Энэ нь “Нэмэлт санхүүжилт олгох тухай гэрээ”-ний 2.2 “Эрдэнэс Тавантолгой ХК нь Төслийн үлдэгдэл санхүүжилтийг Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ байгуулсны дараа үе шаттайгаар шилжүүлнэ”, 3.1.2 “ Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх болон энэ гэрээний хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой асуудлаар Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Ажлын хэсгээр дамжуулан Зүүнбаян төмөр зам ХХК-аас холбогдох төлөвлөгөө, тайлан, мэдээ, дүгнэлт, тодруулгыг заасан хугацаандаа гаргуулан авахаар хэдийд ч шаардах эрхтэй” заалтуудыг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэлгээ хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Олгосон санхүүжилтийн зарцуулалтын тайланг гаргуулан авч, зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавих, хэрэгжилтэд үндэслэн дараагийн санхүүжилтийг олгож байх гэрээний заалтыг мөрдөж ажиллах, хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцож, хянах;

**6. Зардлын данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Байгууллагын зорилтот түвшний төлөвлөгөөнд тусгаагүй зардал гаргаж тайлант жилийн үр дүнг бууруулсан байна.

Энэ нь Компанийн дүрмийн 3.1 “Компани нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, хувьцааны үнийг өсгөхийн төлөө эрмэлзэн ажиллана” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Компанийн дүрэмд заасан үйл ажиллагааны зарчмын дагуу төлөвлөгдөөгүй зардлыг гаргахгүй байхад анхаарч, ажиллах;

**7. Балансын данстай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:**

Авлагын дансны үлдэгдэлд хасагдуулга тооцож байгаа хувь хэмжээг хэрхэн сонгон авч байгаа талаар тусгайлсан журам боловсруулж ажиллахаар компанийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан ч уг журмыг боловсруулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалт зөрчсөн, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Авлага цуглуулах боломжид тулгуурлан авлагын дансанд хасагдуулга тооцож байгаа аргачлалыг тодорхой болгох, авлагын насжилтаас болон өмнөх жилүүдийн авлага цуглуулсан гүйцэтгэлийн статистик мэдээлэл зэрэгт суурилан аргачлал боловсруулж, журам батлуулж мөрдөх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д                             | Байгууллагын нэр       | Аудитын код            | Алдаа зөрчлийн утга   | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга   | Нийт алдаа, зөрчлийн дүн |             | Үүнээс    |     |     |     |                 |             |                   |     |         |     |
|---------------------------------|------------------------|------------------------|---|--|--------------------------|-------------|-----------|-----|-----|-----|-----------------|-------------|-------------------|-----|---------|-----|
|                                 |                        |                        |   |  |                          |             | Залруулга |     | Акт |     | Албан шаардлага |             | Хариуцлага тооцох |     | Зөвлөмж |     |
|                                 |                        |                        |   |  | Тоо                      | Дүн         | Тоо       | Дүн | Тоо | Дүн | Тоо             | Дүн         | Тоо               | Дүн | Тоо     | Дүн |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар |                        |                        |   |  |                          |             |           |     |     |     |                 |             |                   |     |         |     |
| 1.                              | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | Тайлант хугацаанд Төлөөлөн Удирдах Зөвлөл дэх төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 5 гишүүнд цалин хөлсний хэмжээг тогтоосон хязгаараас 32.8 сая төгрөгөөр илүү тооцож олгосон, өмнөх аудитаар өгсөн зөрчлийг арилгах албан шаардлагыг биелүүлж ажиллаагүй байна. | Өмнөх жил өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн..   | 1                        | 32,784.0    |           |     |     |     | 1               | 32,784.0    |                   |     |         |     |
| 2.                              | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | Үндэсний хөрөнгө оруулалтын банкт байгуулсан мөнгөн хөрөнгийг төлж барагдуулах гэрээний хэрэгжилт хангалтгүй байна.   | Мөнгөн хөрөнгийг байршуулах банкныг төлбөрийн чадварын үзүүлэлтийг харгалзан үзэж сонгож байх, үлдэгдэл төлбөрийг яаралтай барагдуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлсэн. | 1                        | -           |           |     |     |     |                 |             |                   | 1   | -       |     |
| 3.                              | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тиан Юу Групп /Tian Yu Group/ компаниас авах 2015 онд үүссэн нүүрсний борлуулалтын 1,208.0 сая төгрөгийн авлага барагдуулалт удааширч, тайлант хугацаанд 100 хувь найдваргүй авлага болгон бүртгэсэн байна.                  | Авлагын төлбөр тооцоог хянаж, хууль хяналтын байгууллагад шилжүүлж, барагдуулах арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлсэн.   | 1                        | 1,208,025.5 |           |     |     |     | 1               | 1,208,025.5 |                   |     |         |     |
| 4.                              | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс Тавантолгой ХК, Шивээ овоо ХК-ийн 2018 онд байгуулсан Зээлийн санхүүжилт олгох гэрээний дагуу Шивээ овоо ХК-д олгосон зээл болон хүүгийн  | Авлагын төлбөр тооцоог барагдуулах, гэрээний биелэлт, хэрэгжилтийг хангуулах албан шаардлага хүргүүлсэн.   | 1                        | 1,473,874.0 |           |     |     |     | 1               | 1,473,874.0 |                   |     |         |     |

|    |                        |                        |   |   |   |             |   |           |  |  |   |   |  |  |  |  |   |             |           |
|----|------------------------|------------------------|---|---|---|-------------|---|-----------|--|--|---|---|--|--|--|--|---|-------------|-----------|
|    |                        |                        | төлбөр 1,473.8 төгрөгийг төлөөгүй, Эрдэнэс Монгол ХХК гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй байна.   |   |   |             |   |           |  |  |   |   |  |  |  |  |   |             |           |
| 5. | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | Эрдэнэс Тавантолгой Майнинг ХХК-аас шилжиж ирсэн болон бусад аж ахуй нэгжид төлөх нийт 3,141.6 сая төгрөгийн өглөг дансанд бүртгэлтэй байгаа ба тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, бодитой эсэх нь нотлогдохгүй байна.  | Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж өглөгийг баталгаажуулах, хэрэв гэрээний үүргээс чөлөөлөгдсөн бол тус өглөгүүдийг тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгах, өглөгийн дансыг үнэн зөв илэрхийлэх; | 1 | 3,141,602.5 |   |           |  |  |   |   |  |  |  |  | 1 | 3,141,602.5 |           |
| 6. | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | 2019 онд үүссэн урьдчилж гарсан зардалд бүртгэлтэй 2 компанид нийт 794.5 сая төгрөг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар балансад бүртгэлтэй хэвээр байна.   | Байгууллагуудтай хийсэн гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, гэрээг дүгнэж, тооцоо нийлэн гэрээг үргэлжлүүлэх шаардлагагүй бол үлдэгдлийг буцаан төлүүлэх арга хэмжээ авах; ;   | 1 | 794,565.1   |   |           |  |  |   |   |  |  |  |  |   | 1           | 794,565.1 |
| 7. | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбоотой өнөөгийн үүрэг хариуцлагыг бүртгэж тайлагнахдаа НББОУС 37 “Нөөц болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө” стандартыг мөрдөж ажиллах талаар өмнөх оны аудитаар зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | Нөхөн сэргээлтийн нөөцийг зохих журмын дагуу тооцоолж мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.  | 1 |             |   |           |  |  | 1 | - |  |  |  |  |   |             |           |
| 8. | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | Бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ өртгөөс өндөр болсон үед бараа материалын үнэ цэнийн бууралтыг 685.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн   | Залруулга хийсэн.   | 1 | 685,520.1   | 1 | 685,520.1 |  |  |   |   |  |  |  |  |   |             |           |

|     |                        |                        |  |  |   |              |   |              |  |  |  |  |  |  |  |  |   |   |
|-----|------------------------|------------------------|--|--|---|--------------|---|--------------|--|--|--|--|--|--|--|--|---|---|
| 9.  | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | Тавантолгой төмөр зам ХХК-ийн хөрөнгө оруулалтын дүнд 14,819.7 сая төгрөгийн хүүгийн орлогыг тооцож бүртгэсэн;   | Залруулга хийсэн.  | 1 | 14,819,726.1 | 1 | 14,819,726.1 |  |  |  |  |  |  |  |  |   |   |
| 10. | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | Богино хугацаатай түрээсийн гэрээг урт хугацаанд түрээслэх хөрөнгөтэй адилтган 4,206.6 сая төгрөгийн ашиглах эрхтэй хөрөнгө бүртгэж, элэгдэл болон хүүгийн зардал тооцсон;                                 | Залруулга хийсэн.  | 1 | 4,206,634.5  | 1 | 4,206,634.5  |  |  |  |  |  |  |  |  |   |   |
| 11. | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | Бүртгэлийн залруулгатай холбоотойгоор татварын зардлыг дахин тооцоолж 189.0 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр үүссэнийг хоорондын зөрүүгээр тус тус залрууллаа.                        | Залруулга хийсэн.  | 1 | 188,950.2    | 1 | 188,950.2    |  |  |  |  |  |  |  |  |   |   |
| 12. | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | Тайлант хугацааны эцэст ашиглалтад байгаа үлдэх өртөггүй 3,875.2 сая төгрөгийн анхны өртөг бүхий биет болон биет бус хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлоогүй байна.  | Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн биет болон биет бус хөрөнгүүд нь цаашид ашиглагдахаар бол дахин үнэлэх, ашиглагдахааргүй бол актлах шийдвэр гаргуулан данс бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлэх;   | 1 |              |   |              |  |  |  |  |  |  |  |  | 1 | - |
| 13. | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн зарцуулалтын тайланд үндэслэн санхүүжилтийг олгох гэрээний заалтыг мөрдөж ажиллаагүй, төслийн санхүүжилтийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна. | Олгосон санхүүжилтийн зарцуулалтын тайланг гаргуулан авч, зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавих, хэрэгжилтэд үндэслэн дараагийн санхүүжилтийг олгож байх гэрээний заалтыг мөрдөж ажиллах, хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцож, хянах; | 1 |              |   |              |  |  |  |  |  |  |  |  | 1 | - |

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

|   |                        |                        |  |  |    |              |   |              |  |  |   |             |  |  |   |             |
|---|------------------------|------------------------|--|--|----|--------------|---|--------------|--|--|---|-------------|--|--|---|-------------|
| 14.   | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | Байгууллагын зорилтот түвшний төлөвлөгөөнд тусгаагүй зардал гаргаж тайлант жилийн үр дүнг бууруулсан байна.  | Компанийн дүрэмд заасан үйл ажиллагааны зарчмын дагуу төлөвлөгдөөгүй зардлыг гаргахгүй байхад анхаарч ажиллах;                         | 1  |              |   |              |  |  |   |             |  |  | 1 | -           |
| 15.   | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | Авлагын дансны үлдэгдэлд хасагдуулга тооцож байгаа хувь хэмжээг хэрхэн сонгон авч байгаа талаар нэгдсэн бодлогогүй байна.  | Авлага цуглуулах боломжид тулгуурлан авлагын дансанд хасагдуулга тооцож байгаа аргачлалыг тодорхой болгож, журам батлуулж мөрдөх;      | 1  |              |   |              |  |  |   |             |  |  | 1 | -           |
| <b>ДҮН</b>  |                        |                        |  |  | 15 | 26,551,682.0 | 4 | 19,900,830.9 |  |  | 4 | 2,714,683.5 |  |  | 7 | 3,936,167.6 |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал |                        |                        |  |  |    |              |   |              |  |  |   |             |  |  |   |             |
| 16.   | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | ТБОНӨХБАҮХА тухай хуулийн хэрэгжилтийн хувьд сонгон шалгаруулалт явуулалгүйгээр босго үнээс давсан 301.2 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.   | Засгийн Газрын 2021 оны 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай" тогтоолоор заасан босго үнийг баримтлах                   | 1  | 301,196.4    |   |              |  |  | 1 | 301,196.4   |  |  |   |             |
| 17.   | Эрдэнэс Тавантолгой ХК | АХГ-2022/61/НА-СТА-ТӨА | Гүйцэтгэх захирлын шийдвэрээр А6/20 бизнес төлөвлөгөөг амжилттай боловсруулсан ажлын хэсгийн ажилтнуудад 128.0 сая төгрөгийн урамшуулал, Хамтын гэрээнд заасны дагуу жилийн ажлын үр дүнгээр нийт ажилчдад 6,020.4 сая төгрөгийн урамшуулал олгосон. | Засгийн газрын Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаарх тогтоолыг хэрэгжүүлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх; | 1  | 6,148,419.8  |   |              |  |  | 1 | 6,148,419.8 |  |  |   |             |
| <b>ДҮН</b>  |                        |                        |  |  | 2  | 6,449,616.2  |   |              |  |  | 2 | 6,449,616.2 |  |  |   |             |
| <b>НИЙТ ДҮН</b>   |                        |                        |  |  | 17 | 33,001,298.2 | 4 | 19,900,830.9 |  |  | 6 | 9,164,299.7 |  |  | 7 | 3,936,167.6 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 643/А0150053  
АХГ-2022/61/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс тавантолгой ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй, босго үнээс давсан 301,196,414.20 төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа Засгийн газраас тогтоосон босго үнийг мөрдөж ажиллах, зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Борлуулалт, худалдан авалт хариуцсан дэд захирал С.Ашидмөнх, Худалдан авах ажиллагааны газрын дарга М.Бат-Эрдэнэ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Б.БЯМБА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khenyev\Alban\_Shaardlaga\2022\0325 Auditin 2 Газар-400.Docx

0001081918





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 644/А0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/611/НА-СТА-ТӨА

Сахилгын хариуцлага тооцох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс тавантолгой ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл дэх төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 5 гишүүнд цалин хөлсний хэмжээг тогтоосон хязгаараас 32,784,000.00 төгрөгөөр илүү тооцож олгосон, өмнөх аудитаар өгсөн зөрчлийг арилгах албан шаардлагыг биелүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7-д "Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3. "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2 заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Цалинг илүү олгосон, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ноогдуулж, төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүдийн цалинг зохих хязгаараас хэтрүүлэхгүйгээр тогтоон, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэс Монгол ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Хуланд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Б.БЯМБА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Kherig\Alban\_Shaardlaga\2022\0325\_Auditin\_2\_Gazar-397.Docx

0001001012





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 645/А/0150053

Улаанбаатар хот

АХС-2022/611/НБ-СТБ-ТӨА  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс тавантолгой ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тиан Юу Групп /Tian YU Group/ компаниас авах 2015 онд үүссэн нүүрсний борлуулалтын 1,208,025,559.16 төгрөгийн авлага барагдуулалт удааширч, тайлант хугацаанд 100 хувь найдваргүй авлага болгон бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг биелүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1. “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал,” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагын төлбөр тооцоог хянаж, хууль хяналтын байгууллагад шилжүүлж, барагдуулах арга хэмжээ авах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Борлуулалт, худалдан авалт хариуцсан дэд захирал С.Ашидмөнх, Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга А.Чинзориг, ерөнхий нягтлан бодогч Д.Алтанцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

*(Handwritten signatures and red stamp)*

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Б.БЯМБА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 646/Н0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/61/НА-СТА-Т0А  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газар, байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбоотой өнөөгийн үүрэг хариуцлагыг бүртгэж тайлагнахдаа НББОУС 37 "Нөөц болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө" стандартыг мөрдөж ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт," 4.2 "Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг хуульд нийцүүлэн санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоож, нийтэд мэдээлнэ. Энэ ангилалд доор дурдсан аж ахуйн нэгж, байгууллагыг заавал хамруулна:", 4.2.4 "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж," гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1 "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй," гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Уурхайн нөхөн сэргээлтийн нөөц сан байгуулах журмыг боловсруулж, үйл ажиллагаанд мөрдөж ажиллах албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль, стандартыг мөрдөж ажиллахыг Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан дэд захирал Б.Жаргалсайхан, Уул уурхай, технологи хариуцсан дэд захирал Н.Батбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ПРОУТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Б.БЯМБА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0325\_Auditin\_2\_Gazar-398.Docx

0001001014



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 647/А.0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/61/НБ-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс Тавантолгой ХК, Шивээ овоо ХК-ийн 2018 оны ЭМГЛ-095/СГ-009/20180605, ЭТТ-2018/17 дугаартай Зээлийн санхүүжилт олгох гэрээний дагуу Шивээ овоо ХК-д олгосон зээл болон хүүгийн төлбөр 1,473,874,000.00 төгрөгийг төлөөгүй, Эрдэнэс Монгол ХХК гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," дээрх гэрээний 4.2-т заасан Эрдэнэс Тавантолгой ХК нь гэрээний хэрэгжилтийг хангуулах зорилгоор Эрдэнэс Монгол ХХК-аас гэрээний биелэлт, хэрэгжилтийг хангуулахыг шаардах эрхтэй" гэж заасныг биелүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал," заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагын төлбөр тооцоог барагдуулах, гэрээний биелэлт, хэрэгжилтийг хангуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Захиргаа, хууль эрх зүй хариуцсан дэд захирал Б.Батсайхан, Хууль, эрх зүйн газрын дарга М.Батбаяр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

*(Signatures)*

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
Б.БЯМБА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

9006109  
9011120010  
10.10.20 Бичиг\_Энрег\Албан Шаардлага\2022\0325 Auditin 2 Газар-401.Docx

0001081970





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 648/А0150053

Улаанбаатар хот

АХГ-2020/64/НА-СТГ-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Тайлант хугацаанд Гүйцэтгэх захирлын шийдвэрээр А6/20 төлөвлөгөөг амжилттай боловсруулсан ажлын хэсэгт ажилласан ажилтнуудад 128,540,000.00 төгрөгийн, Хамтын гэрээнд заасны дагуу жилийн ажлын үр дүнгээр нийт ажилчдад 6,020,419,870.00 төгрөгийн урамшуулал тус тус олгосон нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.3. "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх" гэсэн заалт зөрчсөн, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжүүлж ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Захиргаа, хууль, эрх зүй хариуцсан дэд захирал Б.Батсайханд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Б.БЯМБА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

\\10.10.10.20\Bichig\_Kherel\Alban\_Shaardlaga\2022\0315\_Auditin\_2\_Gazar-370.Docx

0001082023

